



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цэнхэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2026/014/-НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас:

[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг

2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)

Аудитор Л.Соёлмөнх

Утас: 7033-3019

Цахим хаяг: [Soyolmunkhl@audit.gov.mn](mailto:Soyolmunkhl@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.24 № 158  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ч.БАРМИД ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Архангай аймгийн Цэнхэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Сумын 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө байгалийн ургамал ашигласны төлбөр 2,625.1 мянган төгрөгөөр тасарсан;
2. Хоршоо хөгжүүлэх сангийн 11 зээлдэгчтэй холбоотой 60,361.5 мянган төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй;
3. “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүрэгт хамаарахгүй 98,400.0 мянган төгрөгийн ИТХ, ЗДТГ-ын автомашины граш барих ажлыг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.4, 4.5-т, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11, 10 дугаар зүйлийн 10.1, 11 зүйлийн 11.3 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ЗДТГ, ИТХ, Ойн анги, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна. Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 9 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 5,010,160.0 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 3,883,996.2 мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 77.5 хувьтай байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Цэнхэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 112 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс **70.4** хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,013,159.97</b>	<b>2,798,442.72</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,514,001.57	2,406,624.76
33	АВЛАГА	358,170.00	280,378.75
35	БАРАА МАТЕРИАЛ	81,921.51	90,393.91
36	НӨӨЦИЙН БАРАА	59,066.90	21,045.30
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,634,089.98</b>	<b>4,759,143.81</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,634,089.98</b>	<b>4,759,143.81</b>
39200	Биет хөрөнгө	3,377,369.98	4,502,581.31
39300	Биет бус хөрөнгө	256,720.00	256,562.50
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,647,249.96</b>	<b>7,557,586.52</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>32,640.00</b>	<b>120,578.41</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>32,640.00</b>	<b>120,578.41</b>
41300	Өглөг	32,640.00	120,578.41
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,614,609.96</b>	<b>7,437,008.11</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,614,609.96</b>	<b>7,437,008.11</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	656,363.57	656,363.57
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>4,690,739.17</b>	<b>6,513,137.32</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	267,507.22	267,507.22
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,647,249.96</b>	<b>7,557,586.52</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,466,327.96</b>	<b>5,862,734.21</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,423,215.50</b>	<b>1,443,136.30</b>
110	Орлогын албан татвар	759,958.44	646,646.16
1100	Хувь хүний орлогын албан татвар	759,785.44	703,131.47
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(57,015.31)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	173.00	530.00
113	Хөрөнгийн албан татвар	69,053.00	114,871.12
118	Бусад татвар, төлбөр, хураамж	594,204.05	681,619.01
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>957,604.42</b>	<b>4,419,597.91</b>
120	Тусламжийн орлого	-	1,163,132.67
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,085,508.04</b>	<b>-</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,108,577.09</b>	<b>2,382,529.77</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,108,577.09</b>	<b>2,306,971.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,033,320.22</b>	<b>2,285,255.59</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	877,848.08	1,016,886.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,063.25	129,535.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	278,800.64	457,083.68
2104	Хангамж, бараа материалын зардал	97,449.73	100,719.72
2105	Нормативт зардал	-	237.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,584.90	24,503.00
2107	Томилот, зочны зардал	12,398.00	18,600.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	225,440.19	200,905.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	387,735.42	338,743.35
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>75,256.87</b>	<b>21,715.68</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>75,558.68</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>2,357,750.88</b>	<b>3,480,204.43</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,026,862.57</b>	<b>1,657,806.28</b>
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>(1,026,862.57)</b>	<b>(1,657,806.28)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,330,888.31</b>	<b>1,822,398.15</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,962,503.50</b>	<b>4,897,649.50</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,423,215.50</b>	<b>1,443,136.30</b>
110	Орлогын албан татвар	759,958.44	646,646.16
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(57,015.31)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	173.00	530.00
113	Хөрөнгийн албан татвар	69,053.00	114,871.12
118	Бусад татвар, төлбөр, хураамж	594,204.05	681,619.01
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	37,352.55	49,456.53
1181	Газрын төлбөр	383,488.72	449,377.29
	Байгалийн нөөц ашигласны төлбөр	173,362.78	182,785.19
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>441,517.96</b>	<b>3,454,513.20</b>
120	Нийтлэг татварын бус орлого	441,517.96	779,052.02
122	Тусламжийн орлого	-	1,163,132.67
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,512,328.52
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,097,770.04</b>	<b>-</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,796,547.03</b>	<b>2,065,017.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,796,547.03</b>	<b>2,065,017.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,721,290.16</b>	<b>2,043,301.54</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	877,848.08	1,016,886.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,063.25	129,535.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	246,160.64	454,777.83
2104	Хангамж, бараа материалын зардал	90,572.28	94,675.57
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,134.90	30,433.28
2107	Томилолт, зочны зардал	12,398.00	18,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	227,015.40	197,802.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,097.60	100,590.31
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>75,256.87</b>	<b>21,715.68</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,165,956.47</b>	<b>2,832,632.28</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,024,641.07</b>	<b>1,940,009.08</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,024,641.07</b>	<b>1,940,009.08</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	1,024,641.07	1,940,009.08

<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(1,024,641.07)</b>	<b>(1,940,009.08)</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>105,000.00</b>	<b>-</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(105,000.00)</b>	<b>-</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>1,036,315.40</b>	<b>892,623.19</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	477,686.17	1,514,001.57
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,514,001.57	2,406,624.76

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,287,749.36</b>	<b>4,287,749.36</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(4,027.70)	(4,027.70)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,283,721.66	4,283,721.66
9	Тайлант үеийн үр дүн	1,330,888.31	1,330,888.31
<b>10</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,614,609.96</b>	<b>5,614,609.96</b>
<b>11</b>	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>5,614,609.96</b>	<b>5,614,609.96</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,614,609.96	5,614,609.96
19	Тайлант үеийн үр дүн	1,801,706.44	1,822,398.15
<b>20</b>	<b>2025 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл</b>	<b>7,437,008.11</b>	<b>7,437,008.11</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>I</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,034,185.50</b>	<b>2,222,188.32</b>	<b>(1,188,002.82)</b>	<b>214.87</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>931,185.50</b>	<b>1,443,136.30</b>	<b>(511,950.80)</b>	<b>154.98</b>
110	Орлогын албан татвар	599,388.60	646,646.16	(47,257.56)	107.88
1100	Хувь хүний орлогын албан татвар	658,250.00	703,131.47	(44,881.47)	106.82
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(59,000.00)	(57,015.31)	(1,984.69)	96.64
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	138.60	530.00	(391.40)	382.40
113	Хөрөнгийн албан татвар	20,852.10	114,871.12	(94,019.02)	550.89
118	Бусад татвар, төлбөр, хураамж	310,944.80	681,619.01	(370,674.21)	219.21
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	33,272.20	49,456.53	(16,184.33)	148.64
1181	Газрын төлбөр	217,718.80	449,377.29	(231,658.49)	206.40
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	59,953.80	182,785.19	(122,831.39)	304.88
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>103,000.00</b>	<b>779,052.02</b>	<b>(676,052.02)</b>	<b>756.36</b>

120	Нийтлэг татварын бус орлого	103,000.00	779,052.02	(676,052.02)	756.36
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,010,160.00</b>	<b>3,883,996.24</b>	<b>1,126,163.76</b>	<b>77.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,421,976.20</b>	<b>2,024,178.28</b>	<b>397,797.92</b>	<b>83.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,393,414.20</b>	<b>2,012,270.55</b>	<b>381,143.65</b>	<b>84.08</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,067,774.60	1,016,886.65	50,887.95	95.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	133,434.20	129,535.07	3,899.13	97.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	513,068.10	453,077.83	59,990.27	88.31
2104	Хангамж, бараа материалын зардал	105,504.50	82,124.79	23,379.71	77.84
2105	Нормативт зардал	1,000.00	-	1,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,300.00	26,184.00	6,116.00	81.07
2107	Томилолт, зочны зардал	20,994.80	18,600.00	2,394.80	88.59
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	391,519.00	212,940.05	178,578.95	54.39
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,819.00	72,922.16	54,896.84	57.05
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,562.00</b>	<b>11,907.73</b>	<b>16,654.28</b>	<b>41.69</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,500.00	3,195.73	7,304.28	30.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,062.00	8,712.00	9,350.00	48.23
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,493,183.80</b>	<b>1,859,817.96</b>	<b>633,365.84</b>	<b>74.60</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>95,000.00</b>	<b>-</b>	<b>95,000.00</b>	<b>-</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,514,001.57	1,514,001.57	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,406,624.76	2,406,624.76	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>37</b>	<b>37</b>	<b>-</b>	<b>100.00</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>121,030.07</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>121,030.07</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>121,030.07</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	<b>121,030.07</b>
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,030.07
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>111,222.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>71,080.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>71,080.99</b>
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,550.78
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,979.28
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,172.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,668.15
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>40,151.12</b>
23	Дотоод эх үүсвэрээр	40,151.12
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>9,807.96</b>

5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(9,807.96)
---	----------------------------------	------------

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **203,750.0** мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 203,750.0 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- ✓ Үндсэн хөрөнгийн дансанд ЗДТГ-ын 17,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг орхигдуулсан нь УСНББОУС 1, 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1, 13.1 дэх заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үндсэн хөрөнгийн тайланд залруулга хийлгэлээ.
- ✓ Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 186,750.0 мянган төгрөгийг дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлагаар буруу тусгаж тайлагнасан нь УСНББОУС 1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1, 13.1 дэх заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үндсэн хөрөнгийн тайланд залруулга хийлгэлээ.

Мөн аудитаар нийт **161,386.6** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч зөрчил арилгуулах 161,386.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн **161,386.6** мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн албаны хяналтын үр дүнтэй холбоотой санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын 7,317.5 мянган төгрөгийн зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт **168,704.1** мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг зөрчил гэж үзлээ. Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын дүн **56,364.3** мянган төгрөгөөс их байгаа боловч өргөн тархаагүй тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.2 Албан шаардлага

5.2.1. Сумын 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн боловч байгалийн ургамал ашигласны төлбөр 2,625.1 мянган төгрөгөөр тасарсан, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогыг сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэх

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.2. Хоршоо хөгжүүлэх сангийн 11 зээлдэгчтэй холбоотой 60,361.5 мянган төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” гэсэн заалтыг зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг барагдуулах талаар холбогдох хууль, тогтоомжид заасан арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн санг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлэх

5.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 98,400.0 мянган төгрөгийн ИТХ, ЗДТГ-ын автомашины граш барих ажил нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүрэгт хамаарахгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.4-т “Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”, 4.5-т “Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу чиг үүрэгт хамаарах төсөл арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгө орхигдуулсан	1	17,000.0	1	17,000.0			1	17,000.0	-	-	-	-
Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийг үлдэгдлийг буруу тусган тайлагнасан	1	186,750.0			1	186,750.0	1	186,750.0				
<b>НИЙТ ДҮН</b>	<b>2</b>	<b>203,750.0</b>	<b>1</b>	<b>17,000.0</b>	<b>1</b>	<b>186,750.0</b>	<b>2</b>	<b>203,750.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлоготой холбоотой	1	2,625.1	-	-	1	2,625.1			-	-	-	-
ХХС	1	60,361.5	-	-	1	60,361.5						
ОНХС	1	98,400.0	-	-	1	98,400.0						
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1</b>	<b>161,386.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>161,386.6</b>			<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-

## 7. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	669.1	1	669.1	-	-	1	669.1	-	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1</b>	<b>669.1</b>	<b>1</b>	<b>669.1</b>	-	-	<b>1</b>	<b>669.1</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
ЗДТГ	5	41,280.0	-	-	5	41,280.0	-	-	-	-	-	-
ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Ойн анги	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ЭМТ	1	1,437.5	1	1,437.5								
<b>НИЙТ ДҮН</b>	<b>6</b>	<b>42,717.5</b>	<b>1</b>	<b>1,437.5</b>	<b>5</b>	<b>41,280.0</b>	-	-	-	-	-	-